

**СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЦАГ ХУГАЦААНЫ ХУВААРЬ**

**УЛСЫН ИХ ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬ-2019
/Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрог/**

№	Хийгдэх ажил	Хугацаа	
		Хуулийн	Хуанлийн
Нэг. СОНГУУЛЬ ТОВЛОН ЗАРЛАХ			
1	Санал авах өдөр	Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана. <i>(Сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг)</i>	2019.6.30
2	Нөхөн сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох	Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлана. <i>(Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг)</i> <i>(Сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг)</i> <i>(Сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2 дахь хэсэг)</i>	2019.3.01- нээс өмнө
Хоёр. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ ТОГТООХ			
3	Зардлын дээд хэмжээг тогтоох	Төрийн аудитын дээд байгууллага сонгуулийн тойрогт нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг уг тойргийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, хүн амын тоо зэргийг харгалзан санал авах өдрөөс 120-иос доошгүй хоногийн өмнө тогтооно. <i>(Сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг)</i>	2019.3.01- нээс өмнө
		Төрийн аудитын дээд байгууллага сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг санал авах өдрөөс 120-иос доошгүй хоногийн өмнө тогтооно. <i>(Сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг)</i>	2019.3.01- нээс өмнө
Гурав. СОНГУУЛИЙН ХОРООД БАЙГУУЛАХ			
4	Сонгуулийн хороо байгуулах	Сонгуулийн төв байгууллага аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, нийт таваас есөн хүний бүрэлдэхүүнтэйгээр, санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө байгуулна. <i>(Сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэг)</i>	2019.4.21- нээс өмнө
		Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо сум, дүүргийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, нийт таваас есөн хүний бүрэлдэхүүнтэйгээр санал авах өдрөөс 65-аас доошгүй хоногийн өмнө байгуулна. <i>(Сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэг)</i>	2019.4.26- наас өмнө
5	Санал авах байр байгуулах, зохион байгуулагчдыг томилох	Сум, дүүргийн сонгуулийн хороо нь санал авах байрыг санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө байгуулж, ахлах зохион байгуулагчийг томилно. <i>(Сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг)</i>	2019.5.31- нээс өмнө
		Сум, дүүргийн сонгуулийн хороо нь санал авах байрын бусад зохион байгуулагчийг санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө томилно. <i>(Сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг)</i>	
Дөрөв. СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ			
6	Нөхөн сонгууль товлон зарласан тухай шийдвэрийг хүргүүлэх	Ээлжит бус, дахин, нөхөн сонгууль явуулахаар товлон зарласан байгууллага энэ шийдвэрийг ажлын гурван өдрийн дотор аймаг, дүүргийн улсын бүртгэлийн байгууллагаар дамжуулан улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. <i>(Сонгуулийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэг)</i>	Шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор

7	Сонгогчдын нэрийн жагсаалт гаргах, цахим хуудаст байрлуулах	Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтыг эрх бүхий байгууллагаас сонгууль явуулах тухай шийдвэрийг ирүүлснээс хойш өөрийн цахим хуудаст байршуулж , сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрт холбогдох мэдээлэлтэй танилцах боломжоор хангана. (Сонгуулийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.3 дахь хэсэг)	Нөхөн сонгууль явуулах тухай шийдвэр ирүүлснээс хойш
8	Сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах байранд хүргүүлэх	Аймаг, нийслэлийн улсын бүртгэлийн салбар нэгж ээлжит бус, нөхөн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө хэсгийн нэгжид хүргүүлнэ. (Сонгуулийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.6 дахь хэсэг)	2019.6.15-наас өмнө
Тав.НАМ, ЭВСЭЛ СОНГУУЛЬД ОРОЛЦОХОО ИЛЭРХИЙЛЭХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, БҮРТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА			
9	Нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх	Нам, эвсэл нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулийг дагаж мөрдөхөө илэрхийлэн, Улсын Их Хурлын сонгуульд оролцох хүсэлтийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө сонгуулийн төв байгууллагад ирүүлнэ. (Сонгуулийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1 дэх хэсэг)	2019.5.01-нээс өмнө
10	Сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх	Сонгуулийн төв байгууллага сонгуульд оролцох тухай нам, эвслийн баримт бичгийг хүлээн авснаас хойш тав хоногт багтаан сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана. (Сонгуулийн тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.2 дахь хэсэг)	2019.5.05-ны дотор
11	Нам нэр дэвшүүлэх ажиллагааг эхлүүлэх	Сонгуульд оролцох нам, эвсэл нэр дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс 37 хоногийн өмнө эхлүүлж, тав хоногийн хугацаанд дуусгана. (Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.1 дэх хэсэг)	2019.5.24-нөөс 2019.5.28-ны өдрийн хооронд
12	Бие даан нэр дэвшүүлэх	Бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс 37 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана. (Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.2 дахь хэсэг)	2019.5.24-нөөс 2019.5.30-ны өдрийн хооронд
13	Нэр дэвшүүлсэн тухай баримт бичгийг сонгуулийн байгууллагад хүргүүлэх	Нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх хуульд заасан хугацаа дууссан өдрөөс хойш гурав хоногт багтаан баримт бичгийг сонгуулийн төв байгууллагад ирүүлнэ. (Сонгуулийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.2 дахь хэсэг)	2019.5.31-ний дотор
		Бие даан нэрээ дэвшүүлэгч нь бие даан нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх хуульд заасан хугацаа дууссан өдрөөс хойш гурав хоногт багтаан баримт бичгийг сонгуулийн төв байгууллагад ирүүлнэ. (Сонгуулийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.3 дахь хэсэг)	2019.6.02-ны дотор
14	Нэр дэвшигчийг бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэх	Сонгуулийн төв байгууллага нам, эвслээс нэр дэвшигчдийн талаарх баримт бичгийг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор, бие даан нэр дэвшигчийн талаархи баримт бичгийг хүлээн авснаас хойш тав хоногийн дотор бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэж тогтоол гаргана. (Сонгуулийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.8 дахь хэсэг)	2019.6.07-ны дотор

15	Нэр дэвшигчдийг нийтэд мэдээлэх	Сонгуулийн төв байгууллага нэр дэвшигчийг бүртгэх тухай шийдвэр гаргаснаас хойш ажлын гурван өдрийн дотор нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалтыг тойрог болон улсын хэмжээнд нэгтгэж, нийтэд мэдээлнэ. (Сонгуулийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.12 дахь хэсэг)	2019.6.12-ны дотор
16	Нэр дэвшигчийн үнэмлэх олгох	Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл байхгүй бол нэр дэвшигч тус бүрд нэр дэвшигчийн үнэмлэхийг санал авах өдрөөс 22 хоногийн өмнө нэг өдөр олгоно. (Сонгуулийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.9 дэх хэсэг)	2019.6.08-ны өдөр
Зургаа. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА			
17	Сонгуулийн сурталчилгааг эхлүүлэх	Сонгуулийн сурталчилгааг санал авах өдрөөс 18 хоногийн өмнө эхлүүлж санал авах өдрөөс нэг хоногийн өмнө дуусгана. (Сонгуулийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг)	2019.6.12-ноос 2019.6.28-ныг дуустал
18	Сонгуулийн сурталчилгааг зогсоох	Сонгуулийн сурталчилгааг санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00.00 цагаас өмнө зогсооно. (Сонгуулийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.6 дахь хэсэг)	2019.6.29-ний 00:00 цагаас өмнө
Долоо. САНАЛЫН ХУУДАС ХЭВЛҮҮЛЭХ, ХҮРГҮҮЛЭХ			
19	Саналын хуудсыг хэвлүүлэх, хүргүүлэх	Тухайн сонгуулийн саналын хуудасны загвар, тоог сонгуулийн төв байгууллага баталж, эрхлэн хэвлүүлнэ. (Сонгуулийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.11 дэх хэсэг)	2019.6.27-ноос өмнө
		Сонгуулийн төв байгууллага саналын хуудсыг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө санал авах байранд хүргүүлэх ажлыг удирдан зохион байгуулна. (Сонгуулийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.13 дахь хэсэг)	
20	Санал авах байрыг хамгаалалтад авах	Санал авах байранд саналын хуудас хүлээн авснаас хойш санал авах байрыг цагдаагийн хамгаалалтад авна. (Сонгуулийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.11 дэх хэсэг)	Саналын хуудас хүлээн авснаас хойш
Найм. САНАЛ АВАХ, ДҮН ГАРГАХ			
21	Санал авах өдөр, цаг, байрыг нийтэд мэдээлэх	Санал авах байр сонгогчдын санал авах өдөр, цаг, байрыг уг өдөр хүртэлх 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ. (Сонгуулийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.2 дахь хэсэг)	2019.6.16-наас 2019.6.30-ныг хүртэл
22	Санал авах байр, хаягийг нийтэд зарлан мэдээлэх	Санал авах байр санал авах өдрөөс 10 хоногийн өмнө тухайн хэсэг дэх санал авах байрын дугаар, нэр, хаяг, байршил, орчин тойрны дэвсгэр зураг /план/-ийг нийтэд зарлан мэдээлнэ. (Сонгуулийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.8 дахь хэсэг)	2019.6.20-ноос эхлэн
23	Санал авахад шаардлагатай зүйлсийг бэлэн болгох	Тухайн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн Засаг дарга санал авахад шаардлагатай ... зүйлийг сонгуулийн төв байгууллагаас баталсан зааврын дагуу санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө бэлэн болгох үүрэг хүлээнэ. (Сонгуулийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.3 дахь хэсэг)	2019.6.25-наас өмнө
24	Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх сонгогчдын хүсэлтийг	Эрүүл мэндийн байдлын шалтгаанаар зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх сонгогч нь өөрийн эрүүл мэндийн талаарх эмчийн магадлагааг, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтийн хамт санал авах өдрөөс таваас	2019.6.25-наас өмнө

	хүргүүлэх	<p>доошгүй хоногийн өмнө санал авах байранд хүргүүлнэ. (Сонгуулийн тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.2 дахь хэсэг)</p> <p>Дайчлагдсан, саатуулагдсан, баривчлагдсан этгээд болон санал авах үйл ажиллагааг зохион байгуулж байгаа сонгуулийн байгууллагын ажилтан нь зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтээ тухайн байгууллагын удирдлагад өгөх бөгөөд уг хүсэлтийг байгууллагын тодорхойлолтын хамт байгууллагын удирдлага санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө санал авах байранд хүргүүлнэ. (Сонгуулийн тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.3 дахь хэсэг)</p>	
25	Ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх хүсэлтээ хүргүүлэх	<p>Ажиглагч томилох эрх бүхий этгээд ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх хүсэлтээ бичгээр гаргаж, доор дурдсан баримт бичгийн хамт санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө санал авах байранд хүргүүлнэ. (Сонгуулийн тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.8 дахь хэсэг)</p>	2019.6.27-ноос өмнө
		<p>Санал авах байр ажиглагчаар томилогдсон этгээд шаардлага хангасан эсэхийг шалгаж, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 48 цагийн дотор нягтлан шалгаж, шаардлага хангасан этгээдийг бүртгэж, ажиглагчийн үнэмлэх олгоно. (Сонгуулийн тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.10 дахь хэсэг)</p>	2019.6.29-ний дотор
26	Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах	<p>Сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах өдрийн өмнөх өдөр 09:00-20:00 цагийн хооронд авна. (Сонгуулийн тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1 дэх хэсэг)</p>	2019.6.29-ний 09:00-20:00 цаг
27	Санал авах өдөр	<p>Сонгогчдын саналыг Улаанбаатарын цагаар санал авах өдрийн 07:00 цагаас 22:00 цаг хүртэл хугацаанд санал авах байранд авна. (Сонгуулийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэг)</p> <p>Санал авах өдрийн 22:00 цагт сонгогчдын бүртгэлийг зогсоох бөгөөд бүртгэлийн хуудсаа авсан сонгогчдыг саналаа өгөх боломжоор хангана. (Сонгуулийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.11 дэх хэсэг)</p>	2019.6.30-ны 07:00-22:00 цаг
28	Техникийн тооллого хийх	<p>Санал хураалт дууссаны дараа сум, дүүргийн сонгуулийн хороо санамсаргүй сонголт /сугалах/-ын аргаар харьяа хэсгийн хорооноос 50 хүртэл хувийг сонгож 24 цагийн дотор техникийн тооллого хийнэ. Техникийн тооллогод сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн болон сонгогчдын төлөөллийг оролцуулна. (Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.13 дахь хэсэг)</p>	Санал хураалт дууссанаас хойш 24 цагийн дотор
29	Дүн гаргах, нийтэд мэдээлэх	<p>Сонгуулийн Ерөнхий Хороо, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдогчдын нэрийн жагсаалтыг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор гаргаж, Монгол Улсын Ерөнхийлөгчид айлтган нийтэд мэдээлнэ. (Сонгуулийн тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 134.3 дахь хэсэг)</p>	2019.7.15-ны дотор

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО